



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/05

Халбан

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтууд, Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 103 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэцэрлэг сумын Орон нутгийн хөгжлийн сангаар санхүүжигдэх 31.000.000 (гучин нэгэн сая) төгрөгний өртөгтэй Бүрхээр багт ус тээвэрлэх автомашин худалдан авах ажлын гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ч.Амарбаясгалан-(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Гишүүд: Д.Мөнх-Эрдэнэ-(Халбан багийн Засаг дарга)

Т.Оюунсайхан-(Иргэний төлөөлөл)

Х.Билэгсайхан-(Зуунмод багийн Засаг дарга)


Нарийн бичгийн дарга: М.Ренчиндорж-(Засаг даргын Тамгын газрын нярав)

2. Худалдан авах ажиллагааг хууль, журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ч.Амарбаясгалан)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Бямбажав)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.АНХБАЯР



БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ:

ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА Н.АНХБАЯР
(Гарын үсэг)

ГҮЙЦЭТГЭГЧ:

"ӨВӨР АГУЙТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Б.ОЧИРТОЙМ
(Гарын үсэг)

УС ТЭЭВЭРЛЭХ АВТОМАШИН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № ХӨАЦСЗДТГ/202201031

НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг талаас **ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА Н.АНХБАЯР** (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас **"ӨВӨР АГУЙТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ Б.ОЧИРТОЙМ** (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2022 оны 02 сарын 22-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь **УС ТЭЭВЭРЛЭХ АВТОМАШИН НИЙЛҮҮЛЭХ ХӨАЦСЗДТГ/202201031** дугаартай (цаашид "бараа" гэх) **31,000,000 [гучин нэгэн сая]** төгрөг (цаашид "гэрээний үнэ" гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн **31,000,000** төгрөг.

2022 онд: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө **31,000,000** төгрөг.

4. Гүйцэтгэгч Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд **УС ТЭЭВЭРЛЭХ АВТОМАШИН** нийлүүлэх ажлыг 2022 оны 03 сарын 03-ны дотор нийлүүлнэ.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

Бусад шаардлагатай баримт бичиг;

Үнийн санал;

Гэрээний тусгай нөхцөл;

Гэрээний ерөнхий нөхцөл;

Техникийн тодорхойлолт



6. Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

7. Захиалагч талууд нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ харилцан хүндэтгэлтэйгээр асуудалд хандах хэн нэг нь давуу эрх эдлэхгүйгээр хамтын шийдвэр гаргаж ажиллана.

8. Захиалагч гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл түүний хавсралтад заасан эрх үүргийг заавал хэрэгжүүлж хариуцлагыг хүлээнэ.

9. Гүйцэтгэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

10. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн нийлүүлэх бараа болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

12. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, цахим хаягаар харилцана.

13. Зайлшгүй шаардлагааар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож гэрээний үнэнээс бусад асуудлаар зохих өөрчлөлт оруулж болох бөгөөд тус өөрчлөлтийг бичгээр гаргаж талууд баталгаажуулсан нөхцөлд хүчин төгөлдөр болсонд тооцно.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.БЯМБАЖАВ

Хөвсгөл аймаг Цэцэрлэг
сумын ЗДТГ

Утасны дугаар: 99604343

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"ӨВӨР АГУЙТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Б.ОЧИРТОЙМ

Хөвсгөл аймгийн Мөрөн сум

Утас: 88073966

Харилцагч банкны нэр: ХААН БАНК

Дансны дугаар: 5916078289

Регистрийн дугаар: 4141075